



ТАВАНТОЛГОЙ ХК

ӨМНӨГОВЬ АЙМАГ

“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИ

Өмнөговь, Цогтцэций сум, Утас: 7535-5555, 9500-1619

И-мэйл: info@tavantolgoi.mn

2024. 11. 14

№

111166

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Тендерийн баримт бичигт  
өөрчлөлт оруулах тухай

Тус газраас зарласан ТТХК/20240101159 дугаартай “Уурхайн нүүрс ачилтын ажил” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс “Монополын эсрэг” газарт гомдол гарсны дагуу ажлын даалгавар болон тендерийн баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна.

Үүнд:

ТШЗ 26.1: Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут.

ТШЗ 26.2: Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Цаг: 11 цаг 30 минут гэснийг

ТШЗ 26.1: Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут.

ТШЗ 26.2: Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Цаг: 11 цаг 30 минут гэж өөрчлөлт оруулав.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д ажлын даалгаварын хамт байршуулсан.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.ГҮНЖДАГВА

БАТЛАВ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ..... Ч.ГҮНЖДАГВА

УУРХАЙН НҮҮРС АЧИЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР

Нэг. Үндэслэл, ажлын зорилго

Гүйцэтгэгч нь захиалагч талын бизнес төлөвлөгөө, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, мөрдөж буй байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартууд, дүрэм журам, заавар, нүүрс ачих техникийн паспортын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь “Тавантолгой” ХК-ийн 60 гектар талбай дахь нүүрсний овоолгуудаас худалдан авагч талын тээврийн хэрэгсэлд нүүрс ачилтын ажил хийж гүйцэтгэнэ.

Хоёр. Хийгдэх ажил

- 2.1 Нүүрсний овоолгоос худалдааны тээврийн хэрэгсэлд батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу оновчтой техник, тоног төхөөрөмжөөр нүүрс ачна.
- 2.2 Экспортын тээврийн машинд тонн жинд нь тохирсон ачилтыг бүрэн хийж гүйцэтгэнэ.
- 2.3 Нүүрс ачилтын эрчим нэмэгдэх, их ачаалалтай үед нэгэн зэрэг ачилт хийх техникийн нөөцтэй байна.
- 2.4 Нүүрсийг ачилтын явцад бохирдуулан худалдан авагч талд хохирол гаргасан тохиолдолд акт үйлдэж, тухайн жилийн хөрс хуулалтын илтгэлцүүрийн өссөн дүнгээр тооцон хөрсний хэмжээг гаргаж, олборлолтын өргөөр тооцон нүүрс ачилтын гүйцэтгэлээс хасаж тооцно.
- 2.5 Нүүрсний овоолгоос дээжлэлт хийхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг ажиллуулна.
- 2.6 Нүүрсний овоолгод халалт, уугилт гарсан тохиолдолд шатсан нүүрсийг тусгаарлах, шилжүүлэх арга хэмжээ авна.
- 2.7 Ажлын талбай дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс ачилт хийж буй хэсгийн тээврийн зам, ажлын бүс, овоолго бүрд, ажлын талбайн гэрэлтүүлгийг хангалттай хэмжээнд байрлуулна.
- 2.8 Нүүрсний овоолгод овор хэтэрсэн нүүрс гарах тохиолдолд буталж, жижиглэх арга хэмжээг авч ажиллана. Тус арга хэмжээг авч ажиллаагүйгээс шалтгаалсан өмчийн эвдрэл, осол, хохирлыг төлж барагдуулна.
- 2.9 Нүүрсний зах зээлийн нөхцөл байдлаас хамааралтайгаар нүүрс ачилтын эрчим буурч зарим техникуудийг ажлаар хангах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч нь аливаа торгууль болон төлбөрийн хариуцлага хүлээхгүй.
- 2.10 Ачилт, буулгалт хийж гүйцэтгэх ачигч техникийн шанаганд жин хэмжүүр суурилуулан чингэлэгт ачигдах нүүрсний хэмжээг тодорхойлох боломжтой байх бөгөөд ачигдсан тээврийн хэрэгслийг авто жингээр жинлэхэд зөвшөөрөгдсөн жингийн зөрүү үүсэхгүй байх.
- 2.11 Захиалагчийн саналаар захиалагчийн хэрэгжүүлж буй бусад төслийн талбайд гэрээнд заах үнийн дүнгээр төлбөрийг тооцож шилжүүлэн ажиллуулж болно.

Гурав. Инженерийн ажил

- 3.1 Захиалагчийн шаардлагын дагуу гэрээний хавсралтад заасан төлөвлөгөөний тухайн сард гүйцэтгэх ажлын 0.5 хувьд ногдох хэмжээний бүтээлийн бус инженерийн ажлыг хийж гүйцэтгэнэ. Тухайн сард хийгдээгүй инженерийн ажлыг хуримтлагдсан дүнгээр жилийн хэмжээнд тооцон гүйцэтгүүлнэ.
- 3.2 Зам талбайг засах, шинээр тавих шаардлагаар захиалагчийн хамгаалалтын хашааг шилжүүлэх шаардлага үүссэн нөхцөлд гүйцэтгэгч өөрийн зардлаар шилжүүлэн захиалагчид хүлээлгэж өгнө.
- 3.3 Уурхайн гаднах буюу маршрутын замыг захиалагчийн гаргаж өгсөн хуваарийн дагуу зам арчилгааны ажил хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин

- 4.1 Нүүрс ачилтыг гүйцэтгэхдээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг чанд баримтлан ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл ахуйг бүрэн хариуцаж ажиллах бөгөөд холбогдох менежментийн системийг боловсруулан, захиалагчаар батлуулж, гэрээт хугацаанд үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.
- 4.2 Нүүрс ачилтын ажилд зориулан аюулгүй ажиллагааны журам, горим боловсруулан Захиалагч талаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллах бөгөөд шаардлагатай эрсдэлийн үнэлгээг хийсэн байна.
- 4.3 Захиалагч талын инженер техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны /Цаашид ХАБЭАБО гэх/ ажилтнуудыг ажлын талбайд зохих журмын дагуу саадгүй нэвтрүүлэх бөгөөд тэдгээр ажилтны холбогдох дүрэм журамд нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 4.4 ХАБЭАБО-ны талаарх үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээлэхгүй.
- 4.5 ХАБЭАБО-той холбоотой аливаа зөрчил дутагдал гарсан болон цаашилбал хүний амь нас, эрүүл мэндэд хохирол үзүүлж болохуйц аюул, эрсдэлтэй нөхцөл аль нэг ажлын байр болон үйл ажиллагаанд үүссэн тохиолдолд талууд оролцож тэмдэглэл үйлдэн тухайн ажлыг зогсоно.
- 4.6 Гүйцэтгэгч нь үүссэн аюул эрсдэлтэй ажлын байр болон нөхцөлийг бүх ажлын байруудад арилгасны дараа үйл ажиллагааг захиалагчийн зөвшөөрлөөр эхлүүлнэ. Гүйцэтгэгч нь Захиалагчийн зөвшөөрөлгүй буюу засаж залруулах арга хэмжээг хангалтгүй авсан үед үйл ажиллагаагаа дур мэдэн эхлүүлсэн эхний тохиолдолд ХАБЭАБО-ны гүйцэтгэлийг дүгнэх түлхүүр үзүүлэлтийн хөдөлмөрийн аюулгүй байдлын хэсэгт харгалзах оноог бүхлээр нь; 2 дахь удаа уг зөрчлийг давтан гаргаж үйл ажиллагаагаа Захиалагчийн зөвшөөрөлгүй эхлүүлсэн тохиолдолд тухайн сарын гүйцэтгэлийг дүгнэх түлхүүр үзүүлэлтийн ХАБЭАБО хэсэгт харгалзах оноог бүхлээр нь шууд хасах; 3 дахь удаа уг зөрчлийг давтан гаргаж үйл ажиллагаагаа Захиалагчийн зөвшөөрөлгүй эхлүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
- 4.7 ХАБЭАБО-ны гүйцэтгэлийг жил болон сараар дүгнэх, уг дүгнэлтийг сар бүрийн төлбөртэй хэрхэн уялдуулж тооцоолох Гүйцэтгэлийн Түлхүүр Үзүүлэлтийг гэрээнд нарийвчлан тусгана.

Тав. Нүүрс ачилтын үнэлгээ, төлбөрийн нөхцөл

- 5.1 Нүүрс ачилтын үнэлгээ, төлбөр
  - 5.1.1 Уурхайн агуулах дахь нүүрсний овоолгоос худалдааны тээврийн хэрэгсэлд нүүрс ачих ажлын нэгж үнэлгээг 1500 төг/тонноор тооцно.

- 5.1.2 Захиалагч нь төлбөрийг нүүрс ачилтын ажлын гүйцэтгэлээр гүйцэтгэгч талд төгрөгөөр тооцон гэрээнд зааснаар төлнэ.
- 5.1.3 Сар бүрийн эцэст гэрээ дүгнэсэн акт үйлдсэнээс хойш ажлын 3 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ.

Зургаа. Техникийн тоног төхөөрөмж

- 6.1 Нүүрсний ачилт, уурхайн нүүрс овоолгын 60 гектар талбайгаас ачилт хийнэ.
- 6.2 Нүүрс ачилт өдрийн 12 цагаар ажиллах ба шаардлагатай тохиолдолд захиалагчийн шийдвэрийн дагуу 24 цагаар ажиллаж болно.
- 6.3 Захиалагчийн шийдвэрээр 24 цаг ажиллах тохиолдолд шаардлагатай хүний нөөц, машин техникийн нөөцтэй байна.
- 6.4 Уурхайн төлөвлөгөөний дагуу өдөрт 20,000 тонн түүнээс дээш тонн нүүрс ачна.
- 6.5 Техник тоног төхөөрөмж нь
- 7.0 м<sup>3</sup> болон түүнээс дээш утгуурын багтаамжтай утгуурт ачигч 3 ширхэг, 2 ширхэг нь өөрийнх байх.
  - 5.0 м<sup>3</sup> болон түүнээс дээш утгуурын багтаамжтай утгуурт ачигч 3 ширхэг, 2 ширхэг нь өөрийнх байх.
  - 10 тонн болон түүнээс дээш даацтай усалгааны машин -1 ширхэг.
  - Түлшний машин -1 ширхэг.
  - Гэрэлтүүлэгч цамхаг -3 ширхэг /Ligth tower/.
  - Ажилчдын нийтийн унаатай байна.
- 6.6 Дээрх утгуурт ачигчууд нь нүүрсийг автосамосвалын тэвш, контейнерт ачилт хийх боломжтой утгуурын уртасгасан сумтай байх.
- 6.7 Техникийн бэлэн байдал 85 хувиас дээш байх.
- 6.8 Утгуурт ачигчуудын ажилласан мото/цаг нь 2000-аас ихгүй байх.
- 6.9 Өөрийн эзэмшлийнх гэдэгт санхүүгийн түрээсийн гэрээ болон фидуцийн гэрээ, банкны лизинг, зээлээр авсан тоног төхөөрөмжүүд байж болно.
- 6.10 Машин тоног төхөөрөмж нь МУ-ын стандарт хангасан, үзлэг оношилгоонд тэнцсэн байх ба эвдрэл гэмтлээс шалтгаалан захиалагчийн төлөвлөгөө тасрах, тохиолдолд гарсан хохирлыг гэрээнд зааснаар шийдвэрлэнэ.

Хянасан:

Уурхайн төлөвлөлт, ашиглалтын  
хэлтсийн захирал



Л.Ганбат


Хөрөнгө оруулалт, худалдан  
авалтын албаны дарга



Б.Төмөрбаатар

Боловсруулсан:


Борлуулалт, тээвэр логистикийн  
хэлтсийн борлуулалтын ахлах



М.Хосбаяр

## Уурхайд ажиллах тоног төхөөрөмжийн жагсаалт

Зураг.1 Утгуурт ачигчийн нүүрсний овоолгод ажиллах паспорт



Зураг.2 Утгуурт ачигчуудын нүүрсний овоолгод хосолж ажиллах паспорт

